



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 05 өдөр

Дугаар А/126

Чингис хот

Тээврийн хэрэгслийн татвар хураалт,
техникийн үзлэг явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.1, Авто тээврийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд авто тээврийн хэрэгслийн татвар хураалтыг 2021 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор, техникийн хяналтын үзлэгийг жилийн туршид зохион байгуулсугай.

2. Дээрх ажлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга:	Ц.Чогсомжав	Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Б.Ганбат	Аймгийн Авто тээврийн төвийн дарга
Гишүүд:	Э.Мөнх эрдэнэ	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
	А.Гантөмөр	Аймгийн Татварын хэлтсийн дарга
	Л.Мэндбаяр	Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга
	Б.Батсайхан	Аймгийн Цагдаагийн газрын дарга
	Ц.Бат-Эрдэнэ	Мэргэжлийн хяналтын газрын Тээвэр /авто, өргөх механизм/-ийн хяналтын улсын байцаагч

3. Сумдад авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг явуулах хуваарийг 1 дүгээр хавсралтаар, ажлын удирдамжийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

4. Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийг өөрийн нутаг дэвсгэрт байгаа бүх тээврийн хэрэгслийг бүртгэл судалгааны дагуу бүрэн хамруулах, техникийн үзлэгийн өмнө авто тээврийн хэрэгслийн албан татварыг хураан авах ажлыг зохион байгуулсан байхыг сум, багийн Засаг дарга нарт, хуваарьт өдрүүдэд хэв журам сахиулах ажилтнуудаа үүрэгжүүлж, хариуцлагатай ажиллуулахыг Цагдаагийн газрын дарга /цагдаагийн хурандаа Б.Батсайхан/-д тус тус үүрэг болгосугай.

231010353

2.

хураалт, техникийн хяналтын үзлэгт ороогүй тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцохыг хориглон, 2020-2021 онд гаргасан зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллахыг Цагдаагийн газрын дарга /Б.Батсайхан/-д, графикт үзлэгээс хоцорсон тээврийн хэрэгслийг техникийн үзлэгт тухай бүрд нөхөн оруулж байхыг Авто тээврийн төвийн дарга /Б.Ганбат/-д тус тус даалгасугай.

6. Техникийн хяналтын үзлэгт орж байгаа тээврийн хэрэгсэлд ариутгал халдваргүйтгэл хийж жолооч нарын биеийн дулааныг хэмжиж техникийн хяналтын үзлэгт оруулах ажлыг зохион байгуулахыг аймгийн Эрүүл мэндийн газрын дарга /Л.Мэндбаяр/-д даалгасугай.

7. Тээврийн хэрэгслийн татвар хураалт, техникийн хяналтын үзлэгийн үйл ажиллагааг хагас бүтэн жилээр дүгнэн, дүнг танилцуулахыг комиссын дарга /Ц.Чогсомжав /-д үүрэг болгосугай

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ